

STЕК MONGOLIA: БОРЛУУЛАЛТЫН ЗУУЧЛАЛЫН ХӨТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ БОЛОН ЖУРАМ

1. Ерөнхий заалт

1.1. Энэхүү журам нь "STЕК Mongolia" (цаашид "Компани" гэх) болон тус компанийн автомашины будгийн хамгаалалтын хуулгыг (PPF) бусдад сурталчлан борлуулалт хийхээр бүртгүүлсэн "Борлуулалтын зуучлалын түнш" (цаашид "Түнш" гэх) хоорондын харилцааг зохицуулна.

1.2. Түнш нь компанийн албан ёсны бүтээгдэхүүн, үйлчилгээг боломжит хэрэглэгчдэд санал болгосноор борлуулагдсан бүтээгдэхүүнээс урамшуулал авах эрхтэй болно.

2. Бүртгэл

2.1. Хөтөлбөрт 18 насанд хүрсэн хувь хүн эсвэл Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд оролцох боломжтой.

2.2. Түнш нь бүртгүүлэхдээ өөрийн овог нэр, холбоо барих утас, банкны дансны мэдээлэл, татвар төлөгчийн QR-ийг STEK MONGOLIA AFFILIATE веб-д үнэн зөвөөр оруулах.

2.3. Компани нь ямар нэгэн шалтгаан заахгүйгээр түншийн хүсэлтээс татгалзах, эсвэл бүртгэлийг цуцлах эрхтэй.

3. Урамшууллын бүтэц

3.1. Түншийн санал болгосноор борлуулалт амжилттай хийгдсэн тохиолдолд бүтээгдэхүүний НӨАТ-гүй үнийн дүнгээс дараах хувиар бонус тооцно:

- • **3% бонус:** 6,750,000 хүртэлх үнийн дүнтэй бүтээгдэхүүн
- • **4% бонус:** 6,750,001 - 9,000,000 хүртэлх үнийн дүнтэй бүтээгдэхүүн
- • **5% бонус:** 9,000,001 - аас дээш үнийн дүнтэй бүтээгдэхүүн

3.2. Түншийн санал болгосноор борлуулалт амжилттай хийгдсэн тохиолдолд бүтээгдэхүүний НӨАТ-тай үнийн дүнгээс дараах хувиар харилцагч-д хямдрал тооцно:

- • **3% бонус:** 7,500,000 хүртэлх үнийн дүнтэй бүтээгдэхүүн
- • **4% бонус:** 7,500,001 - 10,000,000 хүртэлх үнийн дүнтэй бүтээгдэхүүн
- • **5% бонус:** 10,000,00 - аас дээш үнийн дүнтэй бүтээгдэхүүн

4. Борлуулалт баталгаажуулах ба Хяналт

4.1. **Бүртгэл:** Түнш нь боломжит үйлчлүүлэгчийг Компанид ирэхээс өмнө эсвэл ирэх үед нь Компанийн борлуулалтын менежерт мэдэгдэж, тэмдэглүүлсэн байх.

4.2. **Баталгаажуулалт:** Үйлчлүүлэгч төлбөрөө бүрэн төлж, худалдан авалт дууссаны дараа борлуулалт "Амжилттай" гэж тооцогдоно.

4.3. Хэрэв үйлчлүүлэгч хөтөлбөрт бүртгэлгүй олон түншээс мэдээлэл авсан бол хамгийн анх үйлчлүүлэгчийг бүртгүүлсэн Түншид урамшууллыг олгоно.

5. Төлбөр тооцоо

5.1. Урамшууллыг борлуулалт "Амжилттай" өдрөөс хойш ажлын [3] хоногийн дотор Түншийн бүртгэлтэй банкны дансанд шилжүүлнэ.

6. Түншийн эрх ба үүрэг

6.1. **Эрх:**

- • Түнш нь бүтээгдэхүүний талаарх үнэн зөв мэдээлэл, каталог, зураг болон видео контентоор Компаниас хангуулах эрхтэй.
- • Түнш нь амжилттай болсон борлуулалтаас зохих ёсны урамшууллыг авах эрхтэй

6.2. Үүрэг:

- • Түнш нь бүтээгдэхүүний үнэ, чанар, баталгаат хугацааны талаар зөвхөн Компанийн өгсөн албан ёсны мэдээллийг хэрэглэгчид өгөх үүрэгтэй.
- • Түнш нь Компаниас бүтээгдэхүүнийн сургалтанд заавал хамрагдсан байх.
- • Түнш нь Компаниас өгөгдсөн зураг, лого, видео болон бусад маркетингийн материалыг зөвхөн сурталчилгааны зорилгоор ашиглана. Түнш нь эдгээр материалыг засварлах, өөрчлөх, гуйвуулах эрхгүй.
- • Бүтээгдэхүүний үнийг дур мэдэн нэмэх эсвэл Компанийн нэр хүндэд халдах худал мэдээлэл тараасан тохиолдолд Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу гарсан хохирлыг барагдуулна.
- • Компанийн зөвшөөрөлгүйгээр "Албан ёсны төлөөлөгч" гэх мэтээр өөрийгөө нэрлэж гэрээ байгуулахгүй.

7. Хамтын ажиллагаа цуцлах

7.1. Түнш нь ёс зүйн алдаа гаргасан, хэрэглэгчийг төөрөгдүүлсэн эсвэл гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн тохиолдолд Компани нэг талын санаачилгаар Affiliate эрхийг цуцална.

7.2. Хамтын ажиллагааг цуцалсан тохиолдолд борлуулалтын урамшууллыг олгохгүй.

8. Нууцлал

8.1. Талууд хамтын ажиллагааны явцад олж мэдэж авсан бизнесийн нууц, үйлчлүүлэгчийн мэдээлэл болон борлуулалтын тактикийг гуравдагч этгээдэд задруулахгүй байх үүрэг хүлээнэ.